

2008.06.27

Дугаар 164

### Арилжааны хэлцлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.11 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. 2008 оны 6 дугаар сарын 25-ны өдөр “Монголын хөрөнгийн бирж” ХК-иас зохион байгуулсан 3232 тоот арилжаагаар хийгдсэн “Нако түлш” ХК-ийн 3 300 000 ширхэг хувьцаанд хамаарах 62-185 дугаартай хэлцлүүдийг хүчингүй болгосугай.

2. Энэхүү тогтоолын 1-д заасан хүчингүй болсон хэлцэлтэй холбогдох хувьцаа, мөнгөн хөрөнгийг холбогдох дансанд буцаан байршуулахыг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

3. “БиДиСек” ХК-ийн өмчлөлд буй хувьцааг арилжаалах талаар санал боловсруулж Хороонд танилцуулан зөвшөөрөл авсны үндсэн дээр дахин шинээр арилжаалах ажлыг зохион байгуулахыг “БиДиСек” ХК /Д.Даянбилгүүн/, “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/-д тус тус үүрэг болгосугай.

4. Энэ тогтоолын 1-д заасан саналаа боловсруулахдаа “Нако түлш” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн тоог 50-иас цөөнгүй байхаар тооцохыг “БиДиСек” ХК /Д.Даянбилгүүн/, “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/-д үүрэг болгосугай.

5. Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 134 дүгээр тогтоолын 1-т заасны дагуу өмчилж буй үнэт цаасны 7-640003, 7-640004 тоот дансанд байгаа “Мастер фонд” ХХК, “Мастер фонд 2” ХХК-ийн нийт 5370000 ширхэг хувьцааг хоёрдогч зах зээлийн арилжаа явагдсан эхний өдрөөс эхлэн 1 жилийн хугацаагаар тусгаарлаж хоёрдогч зах зээлийн арилжаанд оруулахгүй байхыг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

6. Энэхүү тогтоолын 1-д заасантай холбогдон гарсан харилцагч, иргэдийн гомдол, аливаа хохирлыг тухай бүр нь барагдуулан ажиллахыг “БиДиСек” ХК /Д.Даянбилгүүн/-д үүрэг болгосугай.

7. 2008 оны 6 дугаар сарын 25-ны өдөр “Нако түлш” ХК-ийн 3 300 000 ширхэг хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааг явуулахдаа Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 16.1.3, 22.3.3-т заасныг зөрчсөн “Монголын хөрөнгийн бирж” ХК болон брокер, дилер, андеррайтерийн “БиДиСек” ХК-ийн холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцож ажиллахыг Улсын ерөнхий байцаагч /Д.Баярсайхан/-д үүрэг болгосугай.

8. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ